

**Аймгийн удирдах ажилтнуудын 2023 оны 03 дугаар сарын 06-ны
өдрийн шуурхай зөвлөгөөнөөс өгсөн үүрэг, даалгавар**

№	Үүрэг даалгавар	Хэрэгжүүлэх хугацаа	Хэрэгжүүлэх байгууллага
1	“Эрүүл аюулгүй-Цэвэр орчин” бүрдүүлэх тухай Байгаль орчин, аялал жуулчлалын сайдын 2023 оны 02 дугаар албан даалгавар, Шинэ сэргэлтийн бодлогын хүрээнд “Иргэддээ ээлтэй цэвэр орчин бүхий-Ногоон хот болох” зорилтыг хэрэгжүүлэхэд орон нутгийн байгууллагууд хамтран ажиллах	2023 оны 04 дүгээр сарын 20-ны дотор	Бүх байгууллагын дарга нар
2	Хот хоорондын авто зам дагуух болон хөдөөгүүр хорогдсон мал, амьтны сэг зэмийг малчид, иргэдийн оролцоотойгоор Мал эмнэлгийн байгууллагын хяналтан доор халдваргүйтгэл хийн устгах, булшлах үйл ажиллагааг зохион байгуулан тайланг БОАЖГ-т хүргүүлэх.	2023 оны 03 дугаар сарын 20-ны дотор	Сумдын Засаг дарга нар МЭГ
3	Нийтийн эзэмшлийн гудамж талбай, усан сан бүхий газрын эрүүл ахуйн хамгаалалтын бүс болон авто замын дагуух хуримтлагдсан хог хаягдлыг төр, хувийн хэвшлийн байгууллагуудын оролцоотой нийтийн их цэвэрлэгээг зохион байгуулах	2023 оны 03 дугаар сарын 20-ны дотор	Сумдын Засаг дарга нар Бүх байгууллага
4	Гудамж талбайд байрлаж байгаа эвдэрсэн хогийн савнуудын таг, хаалгыг засварлаж, сэлбэн ашиглалтын хэвийн үйл ажиллагааг хангах	2023 оны 03 дугаар сарын 20-ны дотор	Сумдын Засаг дарга нар Тохижилт Сүмбэр ОНӨТҮГ
5	Сууршлийн бүсэд байгаа үхэр малыг гаргах, ногоон байгууламж сүйтгэн хог хаягдал тарааж байгаа асуудлыг зогсоох талаар доривтой ажил зохион байгуулах	2023 оны 04 дүгээр сарын 20-ны дотор	Сумдын Засаг дарга нар
6	Хог хаягдлын менежментийг сайжруулж, цэвэр орчин бүрдүүлэхэд иргэдийн оролцоог хангах тал дээр анхаарч багийн дарга нарыг үүрэгжүүлэн, Сууц өмчлөгчдийн холбоодыг идэвхижүүлэх, шинэчлэн байгуулах, үйл ажиллагааг нь сайжруулах асуудлаар тодорхой	2023 оны 03 дугаар сарын 20-ны дотор	Сумдын Засаг дарга нар

	төлөвлөгөө гарган хэрэгжүүлж УАШЗ дээр 14 хоног тутам Сумдын Засаг дарга нар танилцуулга хийх		
7	Төр, хувийн хэвшлийн байгууллагууд гадна орчны их цэвэрлэгээг 14 хоног тутам хийж хэвших, эрүүл, аюулгүй цэвэр орчин бий болгох талаар идэвхи санаачлага гарган ажиллаж сумдын цахим хаягт байршуулан бүх нийтийг уриалсан нөлөөлөлийн ажлуудыг зохион байгуулах	2023 оны 03 дугаар сарын 20-ны дотор	Бүх байгууллагын дарга нар